



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 8/96

Мандалговь

Г

Т

Өмчийн тооллого явуулах
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "г","д", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1, 78 дугаар зүйлийн 78. 2-ын "2","4"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дэрэн суманд байгуулагдсан тэжээлийн ургамал тариалах Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн тооллогыг 2020 оны 4 дүгээр сарын 8-ны өдрөөс 4 дүгээр сарын 10-ны дотор явуулсугай.

Хоёр. Эд хөрөнгийн тооллого явуулах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Н.Эрдэнэ-Очир (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Гишүүд: Ж. Шинэ-Уянга (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Захиргаа, аж ахуйн албаны дарга)

Э.Эрдэнэтунгалаг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын газар тариалангийн үйлдвэрлэлийн технологи хариуцсан мэргэжилтэн)

Ц.Даваа (Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн)

Э.Эрдэнэсүх (Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн)

Хоёр. Эд хөрөнгийн тооллогыг эд хогшил, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг нэг бүрчлэн, нүд үзэж фото зураг, дүрс бичлэгээр баримтжуулан холбогдох журам зааврын дагуу үнэн зөв, чанартай явуулж тооллогын дүнт Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг ажлын хэсэг (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

482010289